# 19.5. Сургалтын төлөвлөгөө импортлох

Сургалтын төлөвлөгөөний мэдээллийг excel файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох excel –файлын загвар нь системийн **Дата импорт -> Сургалтын төлөвлөгөө -> Загвар татах -> ProgramPlanImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.




### Өмнөх нөхцөл

- Сургалтын хөтөлбөр бүртгэсэн байх
- Сургалтын агуулга болох хичээл, дадлага ба ажил, шалгалт бүртгэсэн байх

### Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангиллаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

### Файлын баганын мэдээлэл

| Баганы нэр | Төрөл | Тайлбар | Заавал бөглөх талбар эсэх |
|---|---|---|---|
| Сургалтын байгууллагын код | Текст | Сургалтын байгууллагын кодыг оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код | Заавал |

| | | | |
|---|---|---|---|
| | | буруу оруулсан тохиолдолд алдаа заана.<br>Сургалтын байгууллагын кодыг **Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код** талбараас харна уу! | |
| Сургалтын хөтөлбөрийн код | Текст | Сургалтын кодыг оруулна.<br>Сургалтын хөтөлбөрийн кодыг **Систем** > **Сургалтын хөтөлбөр>индекс** хэсгээс харна уу! | Заавал |
| Сургалтын төлөвлөгөөний код | Текст | Сургалтын төлөвлөгөөний кодыг давхцахгүй байдлаар оруулна. | Заавал |
| Элементийн код | Текст | Элементийн кодыг давхцахгүй байдлаар оруулна. | Заавал |
| Элементийн төрөл | Ганц сонголт | Элементийн төрлийг сонгоно.<br>- Бүлэг */Төлөвлөгөөний хичээлүүдийг бүлэглэж байгаа бүлгийн нэр. Жишээ нь ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээл гэх мэт./*<br>- Хичээл<br>- Шалгалт<br>- Дадлага, Ажил | Заавал |
| Элементийн нэр, код | Текст | - "Элементийн төрөл" нь **"БҮЛЭГ"** үед бүлгийн нэрийг оруулна.<br>*/Жишээ нь ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээл гэх мэт./*<br>- "Элементийн төрөл" нь **"ХИЧЭЭЛ"** үед хичээлийн кодыг оруулна.<br>Хичээлийн кодыг Систем > Сургалтын агуулга>Хичээл>Хичээлийн индекс хэсгээс харна уу!<br>- "Элементийн төрөл" нь **"ШАЛГАЛТ"** үед шалгалтын кодыг оруулна.<br>Хичээлийн кодыг Систем > Сургалтын агуулга>Шал | Заавал |

| | | | |
|---|---|---|---|
| | | галт>Шалгалтын индекс хэсгээс харна уу!<br> - "Элементийн төрөл" нь **"ДАДЛАГА, АЖИЛ"** үед дадлага, ажлын кодыг оруулна. Дадлага, ажлын кодыг Систем > Сургалтын агуулга>Дадлага ба ажил>Дадлага&Ажлын индекс хэсгээс харна уу! | |
| Судлах төрөл | Ганц сонголт | Энэ бүлэг агуулга нь заавал судлах бүлэг үү, сонгон судлах бүлэг үү гэдгийг тохируулна. | Заавал |
| Үе шатын код | Текст | Үе шатын кодыг оруулна. | Заавал |
| Харъяалагдах элементийн код | Текст | Харъяалах элементийн кодыг оруулна. Хичээл, шалгалт, дадлага, ажлын харъяалагдах элементийг кодыг оруулна. **Харъяалах элемент нь зөвхөн ЭЛЕМЕНТИЙН ТӨРӨЛ = "БҮЛЭГ" төрлийн элемент байна.** | Заавал |